



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/337

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цэцэрлэгийн барилгын засвар (Дашинчилэн сум)-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Сувдан элс” ХХК-тай 293 856 420 (хоёр зуун ерэн гурван сая найман зуун тавин зургаан мянга дөрвөн зуун хорь) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Сувдан элс” ХХК-ийн захирал (П.Олзбаяр)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6323010327

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 02-ны өдрийн
А/33 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	5 102 560	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	5 102 560	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	2 551 280	Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн 0.1 хувь	Д.Батцогт
5	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн
6	Гүйцэтгэлийн баталгаа	8 815 692.6	Д.Батцогт